




Хүсээгүй жирэмслэлт ба Үр хөндөлт





Үр хөндөлт



Үр хөндөлтийг эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврын шаардлагыг хангасан, гарч болох хүндрэлээс сэргийлэх, эмчлэх бэлтгэлийг бүрэн хангасан, хүндрэлээс сэргийлэх, хүндрэл гарсан тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх бэлтгэл бүрэн хангагдсан, 24 цагаар үйлчилгээ үзүүлдэг, “Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах” тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт, эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй эмч үр хөндөхийг зөвшөөрнө.



Үр хөндөлт




Эрт үеийн

Жирэмсний 12+6 долоо
хоногийн дотор эхийн өөрийн
хүсэлтээр хийгдэнэ.



Хожуу үеийн

Мэргэжлийн эмч нарын
дүгнэлт, зөвлөгөөний
шийдвэрээр хийнэ.



Шинжилгээ 02.

Эмч шаардлагатай шинжилгээнүүдийг
таньд зөвлөнө. Мазокийн шинжилгээнд
үтрээний үрэвсэл оношлогдсон
тохиолдолд **ЗАЙЛШГҮЙ ЭМЧИЛГЭЭ**
ХИЙНЭ.





/Эрүүл мэндийн сайдын 2019 оны 08 сарын 15-ны өдрийн А/387
дугаар тушаалын 6-р заалтын дагуу/



03. Хэт авиан шинжилгээ



Хэт авиан шинжилгээгээр жирэмсний тээлтийн хугацааг тодорхойлно.



Өсөлтгүй жирэмсэн, эрт үеийн зулбалт, умайн гаднах жирэмсэн, цулцан хураагаас ялган оношлох шаардлагатайгаас гадна өмнө нь кесар мэс заслаар төрсөн бол сорвины байдлыг давхар үнэлэх шаардлагатай.



Үр хөндөлт

Жирэмсний тээлтийн хугацаанаас хамааран багаж болон аргаар ураг зулбуулах аргыг эмч таньд санал болгоно.

Жирэмсний хугацаа бага байх тусам гарах эрсдэл, хүндрэлээс сэргийлэх боломж нэмэгдэнэ.



Хүндрэл

01.

Халдвар

Үрэвсэл, халдварын улмаас умай дайврыг хамарсан идээт үрэвслээр хүндэрч умай авагдах эрсдэлтэй.

03.

Умайд дахин ажилбар хийгдэх

Умайн хөндийд шавхрага хуримтлагдах, жирэмсний эд үлдэх. Умайн салстын наалдац үүсэж, БЮ хоригдох

02.

Цус алдалт

Умайн агшилт суларсны улмаас их хэмжээний цус алдах эрсдэлтэй. Цус цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх, умай авагдах эрсдэлтэй.

04.

Үргүйдэл

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

